



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 03 өдөр

Дугаар А/02

Ховд

Дотоод аудитын хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.12 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, түүний дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд явуулсан дотоод аудитын тайланг хэлэлцэн шийдвэрлэх, дотоод аудитын нэгжийн үйл ажиллагаанд зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй аймгийн Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Хорооны дарга: М.Амарсанаа (Аймгийн Засаг дарга)

Гишүүд: Э.Уртнасан (Аймгийн Засаг даргын орлогч)

Б.Батнасан (Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Н.Ганзориг (Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга)

Ж.Цэнд-Аюуш (Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Ч.Мөнхцоож (Мэргэшсэн нягтлан бодогч, аудитор)

Нарийн бичгийн дарга:

П.Мягмартүвшин (Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны улсын ахлах байцаагч)

2. Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, санхүүгийн хяналт болон дотоод аудитын тайланг хэлэлцэж, үйл ажиллагаанд нь зөвлөгөө, дэмжлэг үзүүлж ажиллахыг Дотоод аудитын хороонд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.АМАРСАНАА

8400001 0006 Zan A/02 Kh